

# САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## 2023/02

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.II	2022.II	2023.I	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2022 оны эцэст	их наяд ₮, оны үнээр	-	-	52.9 2022.IV	-	1.1%▲	-	4.8%▲
Инфляц	хувь	12.2%	14.2%	12.3%	-0.1 нэгж хувиар▼	-	2.4%▲	-2 нэгж хувиар▼
Ажилгүйдлийн түвшин	хувь	-	-	5.3% 2022.IV	-	0.1%▼	-	-2.8%▼
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	22.6	32.2	-31.6	-	-	-	-9.6▼
Ам.долларын ханш	төгрөг	3,508.06	2,857.17	3,467.21	40.85▲	-	-	650.89▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	1045.32	142.5	389.7	-	-	-	902.8▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	8.0	1.3	3.6	22.2%▲	-	-	615%▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	218.5	212.3	110.7	-2.6%▼	-	-	2.9%▲
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	6.5%	13%	0%	-	0%	6.5%▲
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	3.39	3.68	3.56	-4.8%▼	-	-	-7.9%▼
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	9.93%	10.13%	9.00%	0.93% нэгж хувиар▲	-	-	-0.2% нэгж хувиар▼

### ОНЦЛОХ СТАТИСТИК:

<ul style="list-style-type: none"> <li>Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл өмнөх сараас 10.9%-иар өсжээ.</li> </ul>	Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2023 оны 2 дугаар сарын эцэст 2.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 221.5 (10.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 89.7 (4.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.9 хувийг эзэлж байна.
<ul style="list-style-type: none"> <li>Экспорт өмнөх сараас 8.2%-иар өслөө.</li> </ul>	2023 оны эхний 2 сард нийт гадаад худалдааны нийт бараа эргэлт 3.4 тэрбум америк доллар болж экспорт өмнөх сараас 88.1 (8.2%) сая америк доллароор өссөн бол импорт 177.8 (25.8%) сая америк доллароор буурсан байна.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөрөнгө оруулалт, худалдааны газар” байгуулав	2023/02/01	Хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, зорилтот улс, бүс нутаг, эдийн засгийн салбар, тэргүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, дэмжлэг үзүүлэх, худалдааны эргэлтийг сайжруулах, импортыг орлох салбарыг хамгаалах, экспортыг дэмжих, эдийн засгийн төрөлжилтийг гүнзгийрүүлэх, худалдааг хөнгөвчлөх, дүн шинжилгээ хийх нөхцөл бүрдэнэ.
2. ЖДҮ хөгжүүлэх сангаас 28.4 тэрбум төгрөгийн зээл олгохоор болжээ.	2023/02/10	ЖДҮ-чдийг дэмжих зорилгоор нийслэлд 7 тэрбум, хөдөө орон нутагт 21.4 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөж байна.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### График

#### Нөлөөлөл


#### Инфляц



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 12.2 хувь, өмнөх оны эцсээс 2.4 хувь, өмнөх сараас 1.2 хувиар өссөн байна.

Инфляц өмнөх сараас 1.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.5 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

#### Валютын ханш




Америк долларын ханш 3508.06 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 650.89 төгрөгөөр, өмнөх сараас 40.85 төгрөгөөр суларсан байна. Харин төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2023 оны 2 дүгээр сард 513.80 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 63.29 төгрөгөөр, өмнөх сараас 3.40 төгрөгөөр суларсан байна.

Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас -4.63%-иар буурч, 3.39 тэрбум ам.долларт хүрээд байна.

#### Улсын төсөв


(тэрбум төгрөг)



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ урьдчилсан гүйцэтгэлээр 3.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 422.9 (16.4%) тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 2.8 их наяд төгрөг болж, 318.7 (12.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2.8 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн тэнцэл 22.6 тэрбум төгрөгийн ашигтай гарч, төсвийн алдагдал өмнөх оны мөн үеэс 9.6 (29.8%) тэрбум төгрөгөөр буурчээ.

#### Гадаад худалдаа



Гадаад худалдааны нийт бараа эргэлт 3.4 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 2.2 тэрбум ам.доллар, импорт 1.2 тэрбум ам.доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.2 (55.2%) тэрбум ам.доллаар, экспорт 1.1 (90.1%) тэрбум ам.доллаар, импорт 160.5 (15.5%) сая ам.доллаар тус тус өсжээ. Гадаад худалдааны тэнцэл 2023 оны 2 дугаар сард 655.6 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 265.9 (68.2%) сая америк доллароор өссөн байна.

#### Дэлхийн эдийн засагт

- НҮБ: Энэ онд дэлхийн худалдааны өсөлт саарах төлөвтэй  
Дэлгэрэнгүйг: <https://bloombergtv.mn/news/g1p1c5>
- АНУ-ын Төв банк бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар өсгөлөө.  
Дэлгэрэнгүйг: <http://eagle.mn/r/112481>

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 2-р сар 2023 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 2-р сар 2023 он, Монголбанк
3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)